



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

### НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрөл, хамрах хүрээг тогтоох, нийгмийн халамжийн сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг зарцуулах, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж

2.1.Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."нийгмийн халамж" гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг;

3.1.2."нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн" гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг;

3.1.3.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг

[/Энэ заалтыг 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

3.1.4."ахмад настан" гэж Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг;

3.1.5."хөгжлийн бэрхшээлтэй иргэн" гэж Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг;

3.1.6."байнгын асаргаа шаардлагатай иргэн" гэж бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнийг;

3.1.7."бүтэн өнчин хүүхэд" гэж эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг;

3.1.8."өрх толгойлсон эх /эцэг/" гэж нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие

эх /эцэг/-ийг;

3.1.9."төрөлжсөн асрамжийн үйлчилгээ" гэж асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагааг;

3.1.10."олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ" гэж иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг.

3.1.11."босго шугам" гэж нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас энэ хуулийн 29.1-д заасан мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийг амьжиргааны түвшингээр эрэмбэлж оноо өгөх байдлаар тогтоосон хязгаарыг.

[/Энэ заалтыг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

#### **4 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн хамрах хүрээ**

4.1.Нийгмийн халамжийн үйл ажиллагаанд энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан болзол, шалгуур, нөхцөлийг хангасан Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суудаг гадаадын иргэн, харьяалалгүй хүн хамрагдах эрхтэй.

#### **5 дугаар зүйл.Нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл**

5.1.Нийгмийн халамжийн үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна:

- 5.1.1.нийгмийн халамжийн тэтгэвэр;
- 5.1.2.нийгмийн халамжийн тэтгэмж;
- 5.1.3.нийгмийн халамжийн үйлчилгээ;
- 5.1.4.нийгмийн хөгжлийн үйлчилгээ.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН**

#### **6 дугаар зүйл.Нийгмийн халамжийн сан, түүний бүтэц**

6.1.Нийгмийн халамжийн сан /цаашид "халамжийн сан" гэх/ нь мөнгөн хөрөнгийн сан байна.

6.2.Халамжийн сан дараах төрөлтэй байна:

- 6.2.1.тэтгэвэр, тэтгэмжийн сан;
- 6.2.2.нийгмийн үйлчилгээний сан.

#### **7 дугаар зүйл.Халамжийн сангийн орлогын эх үүсвэр**

7.1.Халамжийн сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- 7.1.1.улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;
- 7.1.2.сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;
- 7.1.3.олон улсын байгууллага, гадаад улсаас өгсөн хандив, тусламж;
- 7.1.4.аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж;
- 7.1.5.бусад эх үүсвэр.

7.2.Халамжийн сангийн орлого бүх төрлийн татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

#### **8 дугаар зүйл.Халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт**

8.1.Тэтгэвэр, тэтгэмжийн сангийн хөрөнгийг зөвхөн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид зарцуулна.

8.2.Нийгмийн үйлчилгээний сангийн хөрөнгийг дараах үйлчилгээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна:

- 8.2.1.амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж;
- 8.2.2.олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ;

8.2.3.төрөлжсөн асрамжийн үйлчилгээ;

8.2.4.нийгмийн хөгжлийн үйлчилгээ;

8.2.5.шинэ төрлийн үйлчилгээ турших болон хууль тогтоомжийн өөрчлөлтийн улмаас нийгмийн халамжаас хасагдсан иргэнд үзүүлэх үйлчилгээний зардал;

8.2.6.энэ хуулийн 27.1-д заасан Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшуулал;

8.2.7.нийгмийн ажилтны чадавхийг бэхжүүлэх, мэргэшүүлэх сургалт, бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, шинэчлэхтэй холбогдсон зардал;

8.2.8.нийгмийн халамжийн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх судалгаа, шинжилгээ, үнэлгээний зардал;

8.2.9.холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрсөн бусад үйлчилгээний зардал.

8.3.Халамжийн сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.

## **9 дүгээр зүйл.Халамжийн санд улсын төсвөөс олгох хөрөнгө**

9.1.Халамжийн санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг Засгийн газрын саналыг харгалзан Улсын Их Хурал жил бүрийн төсвийн тухай хуулиар тогтооно.

## **10 дугаар зүйл.Халамжийн сангийн тайлан тэнцэл гаргах, тайлагнах**

10.1.Халамжийн сан тус бүрийн орлого, зарлагын тайланг дор дурдсан хугацаанд гаргаж тайлагнана:

10.1.1.сум, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага улирлын тайланг тухайн улирлын дараа сарын 10-ны дотор, жилийн эцсийн нэгдсэн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор тус тус гаргаж аймаг, нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлэх;

10.1.2.аймаг, нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага улирлын тайланг тухайн улирлын дараа сарын 15-ны дотор, жилийн эцсийн нэгдсэн тайланг дараа оны 01 дүгээр сарын 20-ны дотор тус тус гаргаж нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

10.1.3.нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага халамжийн сангийн улирлын нэгдсэн тайланг тухайн улирлын дараа сарын 25-ны дотор, жилийн эцсийн нэгдсэн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор тус тус гаргаж нийгмийн халамжийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлэх.

10.2.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага халамжийн сангийн жилийн эцсийн нэгдсэн тайлан тэнцлийг хянан хэлэлцэж, дүгнэлт гаргана.

## **11 дүгээр зүйл.Халамжийн сангийн мэдээ, тайлангийн маягтыг батлах**

11.1.Халамжийн сангийн мэдээ, тайлангийн маягтын загварыг санхүү, төсвийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ**

## **12 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тэтгэвэр**

12.1.Нийгмийн халамжийн тэтгэвэр /цаашид "тэтгэвэр" гэх/-ийг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэвэр авах эрх үүсээгүй дараах иргэнд сар бүр олгоно:

[/Энэ хэсэг т 2018 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

12.1.1. эрэгтэй 60, эмэгтэй 55 болон түүнээс дээш настай иргэн;"

[/Энэ заалтыг 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан /](#)

[/Энэ заалт ад 2018 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

12.1.2.16 насанд хүрсэн одой иргэн;

12.1.3.хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

12.1.4.тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд;

12.1.5.18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг.

## **13 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тэтгэмж**

13.1. Нийгмийн халамжийн тэтгэмж /цаашид "тэтгэмж" гэх/ дараах төрөлтэй байна:

13.1.1. асаргааны тэтгэмж;

13.1.2. нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмж;

13.1.3. онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж;

~~13.1.4. жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж.~~

[/Энэ заалтыг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болсон/](#)

~~13.1.5. хүүхдийн мөнгөн тэтгэмж.~~

[/Энэ заалтыг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

[/Энэ заалтыг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

13.1.6. хүүхдийн мөнгөн тэтгэмж.

[/Энэ заалтыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.2. Асаргааны тэтгэмжийг дараах иргэнд олгоно:

13.2.1. бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа;

[/Энэ заалтад 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

13.2.2. Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан байгаа;

[/Энэ заалтад 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

13.2.3. тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;

13.2.4. эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа.

13.3. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмжийг энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн-иргэнд сар бүр олгоно.

13.4. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд тэтгэмж олгох нөхцөл, болзлыг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна.

13.5. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг дор дурдсан өрх, иргэнд олгоно:

13.5.1. гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх;

13.5.2. 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн;

13.5.3. хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;

[/Энэ заалтыг 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

13.5.4. нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эх;

[/Энэ заалтыг 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

~~13.5.5. энэ хуулийн 19.2.4-т зааснаас бусад хоёр ба түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мөнд өсгөж байгаа өрх, иргэн;~~

[/Энэ заалтыг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болсон/](#)

13.5.6. байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхдэд Засгийн газраас тогтоосон тухайн үеийн нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцүү хэмжээний тусламжийг.

[/Энэ заалтыг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

13.5.7.байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн;

13.5.8.гурав ба түүнээс дээш тооны 14 хүртэлх насны хүүхдтэй өрх төлгөйлсөн эх /эцэг/;

[/Энэ заалтыг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон/](#)

13.5.9."Эхийн алдар" нэгдүгээр зэргийн одон, эсхүл "Эхийн алдар" хоёрдугаар зэргийн одонтой эх мөнгөн тусламж давхардуулахгүйгээр.

13.6.Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг энэ хуулийн 13.5.1-13.5.4-д заасан өрх, иргэнд нэг удаа, энэ хуулийн 13.5.6-д заасан хүүхдэд сард нэг удаа, энэ хуулийн 13.5.7-д заасан иргэнд улиралд нэг удаа, энэ хуулийн 13.5.9-д заасан иргэнд жилд нэг удаа тус тус олгоно.

[/Энэ хэсэг т 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан/](#)

13.7.Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхдтэй эхийн тэтгэмжийг эхэд жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар бүр өлгөнө.

[/Энэ хэсгийг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон/](#)

13.8.Энэ хуулийн 13.7-д заасан эх хүүхдээ төрүүлсний дараа нас барсан бол уг хүүхдийн эцэг, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, үрчилж авсан эх /эцэг/ нь тэтгэмжийг үргэлжлүүлэн авах эрхтэй.

[/Энэ хэсгийг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон/](#)

13.9.Энэ хуулийн 13.2-т заасан иргэнийг асаргаа, сувилгааны болон асрамжлах үйлчилгээний ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах бөгөөд уг сургалтын зардлыг нийгмийн үйлчилгээний сангаас санхүүжүүлнэ.

13.10.Энэ хуулийн 13.9-д заасан сургалтыг зохион байгуулах журам болон сургалтын хөтөлбөрийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

13.11.Энэ хуулийн 13.2.4-т заасан ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, өвчин, гэмтлийн жагсаалтыг эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

[/Энэ хэсгийг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

13.12.Энэ хуулийн 13.1.5-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журмыг Засгийн газар батална.

[/Энэ хэсгийг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

[/Энэ хэсгийг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

13.13.Энэ хуулийн 13.1.6-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журмыг Засгийн газар батална.

[/Энэ хэсгийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

#### **14 дүгээр зүйл.Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдөл гаргах, шийдвэрлэх хугацаа**

14.1.Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авахыг хүссэн иргэн холбогдох баримт бичгийг бүрдүүлж, өргөдлийн хамт сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө.

14.2.Сум, хорооны нийгмийн ажилтан тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлүүлнэ.

14.3.Тэтгэвэр, тэтгэмж авах иргэний дэвтэр, маягтын загварыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

#### **15 дугаар зүйл.Тэтгэвэр, тэтгэмж олгох**

15.1.Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тэтгэвэр, тэтгэмжийг банкаар дамжуулан олгоно.

15.2.Тэтгэвэр, тэтгэмж авагч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрөө хүсэлт гаргавал улиралд олгох тэтгэвэр, тэтгэмжийг тухайн улирлын эхний сард бөөнөөр нь олгож болно.

15.3.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж тэтгэвэр, тэтгэмжээ авах боломжгүй иргэний тэтгэвэр, тэтгэмжийг түүний итгэмжлэгдсэн иргэнд, эсхүл нийгмийн халамжийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан гэрт нь хүргэж өгнө.

15.4.16 хүртэлх насны хүүхдэд олгох тэтгэвэр, тэтгэмжийг эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь олгоно.

15.5.Иргэн хүсэлтээ гаргасан тохиолдолд нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тэтгэвэр, тэтгэмжийг тухайн иргэний хадгаламжийн дансанд нь шилжүүлж болно.

#### **16 дугаар зүйл.Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, олгох журам**

16.1.Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг тухайн үед мөрдөж байгаа хүн амын амьжиргааны доод түвшингийн хэмжээг үндэслэн Засгийн газар тогтооно.

16.2.Тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журмыг Засгийн газар батална.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

#### **17 дугаар зүйл.Нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл**

17.1.Нийгмийн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

17.1.1.олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ;

17.1.2.төрөлжсөн асрамжийн үйлчилгээ.

#### **18 дугаар зүйл.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ**

18.1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

18.1.1.амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;

18.1.2.зөвлөгөө өгөх;

18.1.3.сэргээн засах үйлчилгээнд хамруулах;

18.1.4.түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах;

18.1.5.өдрийн үйлчилгээнд хамруулах;

18.1.6.гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;

18.1.7.иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;

18.1.8.гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;

18.1.9.нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах.

18.1.10.гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах.

[/Энэ заалтыг 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

18.2.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд дараах өрх, иргэн хамрагдана:

18.2.1.ахмад настан;

18.2.2.хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

18.2.3.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд

[/Энэ заалтыг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

18.2.4.хүчирхийлэлд өртсөн иргэн;

18.2.5.хорих ангиас суллагдсан иргэн;

18.2.6.согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн;

18.2.7.эдгэшгүй хүнд өвчтэй хүн;

18.2.8.гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн;

18.2.9.шилжин суурьшсан энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн-иргэн, иргэн;

18.2.10.өрх толгойлсон эх /эцэг/.

18.2.11.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх.

[/Энэ заалтыг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

18.2.12.гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн хүүхэд.

[/Энэ заалтыг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

18.3.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тооцож нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

18.4.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улсын хэмжээнд дүнг нэгтгэн жил бүрийн төсвийн төсөлд тусгана.

18.5.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 17.1-д заасан үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

18.6.Энэ хуулийн 18.5-д заасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ.

18.7.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар болон үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал, зааврыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

18.8.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18.9.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг энэ хуулийн 18.8-д заасны дагуу магадлан итгэмжлэх журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

## **19 дүгээр зүйл.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ**

19.1.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

- 19.1.1.ахмад настны асрамжийн үйлчилгээ;
- 19.1.2.хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн үйлчилгээ;
- 19.1.3.хүнд нөхцөлд байгаа 18 хүртэлх насны хүүхдийн асрамжийн үйлчилгээ;
- 19.1.4.гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн үйлчилгээ.

19.2.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд дараах иргэнийг хамруулна:

- 19.2.1.тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх хүүхэд нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй улмаас дэмжлэг, туслалцаа үзүүлэх чадваргүй, тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь тухайн ахмад настны эсрэг хүчирхийлэл үйлдсэн болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй ахмад настан;
- 19.2.2.мэргэжлийн үйлчилгээ, тусгай нөхцөл шаардагдсан болон тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
- 19.2.3.хүнд нөхцөлд байгаа, Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон байнгын асрамжид байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхэд;
- 19.2.4.улсын зардлаар төрөлжсөн асрамжийн газар асрамжлан өсгөхийг эцэг, эх нь зөвшөөрсөн дөрөв хүртэлх насны гурав ба түүнээс дээш ихэр хүүхэд.

19.3.Энэ хуулийн 19.1.2, 19.1.3-т заасан асрамжийн үйлчилгээг үйлчлүүлэгчийн өвөрмөц хэрэгцээ, нас, хүйсийн онцлогийг харгалзан нарийвчлан ангилж, төрөлжүүлж болно.

19.4.Энэ хуулийн 19.2.1-19.2.4-т заасан хүүхэд ба иргэнийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга гаргана.

19.5.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэний дор дурдсан зардлын норматив, эд хөрөнгийн эдэлгээний хугацаа, журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж мөрдүүлнэ:

- 19.5.1.хоол хүнс, хувцас, эм, ариун цэврийн болон хичээлийн хэрэглэгдэхүүний нэг хүнд ногдох зардлын норматив, эдэлгээний хугацаа;
- 19.5.2.нас барсан иргэнийг оршуулах зардлын норматив.

19.6.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

[/Энэ хэсэгт 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

19.7.Төрөлжсөн асрамжийн газарт асруулагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах, төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх болон түүний төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.8.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр авагч ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэний тогтоогдсон тэтгэврийнх нь 70 хувийг асруулж байгаа иргэнд, 30 хувийг тухайн асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагад нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний

баталсан журмын дагуу олгоно.

19.9.Нийгмийн халамжийн үйлчилгээг энэ хуулийн 18.2, 19.2-т зааснаас бусад өрх, иргэний хүсэлтийн дагуу төлбөртэй үзүүлж болох бөгөөд тухайн үйлчилгээний төлбөрийн хэмжээг үйлчлүүлэгчтэй хэлэлцэн тогтооно.

19.10.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах үйлчилгээ, өдрийн үйлчилгээг үзүүлэх, тухайн хүүхдийг хөгжүүлэх төв, төрөлжсөн асрамжийн үйлчилгээг холбогдох стандартын дагуу зохион байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх асуудлыг нийгмийн халамжийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

### **НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

#### **20 дугаар зүйл.Боловсролыг дэмжих үйлчилгээ**

20.1.Боловсролыг дэмжих үйлчилгээний хүрээнд дараах тусламж, дэмжлэг үзүүлнэ:

20.1.1.энэ хуулийн 20.2-т заасан хүүхэд сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа бол хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт.

20.2.Боловсролыг дэмжих үйлчилгээнд дараах иргэнийг хамруулна:

20.2.1.энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн-иргэний болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүүхэд;

20.2.2.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд;

20.2.3.бүтэн ба хагас өнчин хүүхэд;

20.2.4.гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэний хүүхэд;

20.2.5.төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхэд;

20.2.6.хорих ангиас суллагдсан хүүхэд.

20.2.7.энэ хуулийн 3.1.11-д заасан босго шугамаас доогуур амьжиргаатай өрх толгойлсон эх, эцгийн хүүхэд.

[/Энэ заалтыг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

20.3.Энэ хуулийн 20.2.2, 20.2.4, 20.2.6-д заасан хүүхэд албан бус сургалтад хамрагдаж байгаа бол түүнд энэ хуулийн 20.1.1-д заасан хөнгөлөлтийг бүрэн буюу хэсэгчлэн олгоно.

20.4.Энэ хуулийн 20.2.5-д заасан хүүхэд асрамжийн газраасаа боловсролын зардал авч байгаа бол энэ хуулийн тусламж, дэмжлэгийг давхардуулан олгохгүй.

20.5.Боловсролыг дэмжих үйлчилгээг нийгмийн халамжийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталж, тус тусын үзүүлэх тусламж, дэмжлэгийн зардлыг тухайн Засгийн газрын гишүүний төсвийн багцаас гаргана.

#### **21 дүгээр зүйл.Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ**

21.1.Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээний хүрээнд дараах тусламж, дэмжлэг үзүүлнэ:

21.1.1.энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн-гишүүн иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бүрэн болон хэсэгчлэн төлөх;

21.1.2.нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлэх эрүүл мэндийн бусад үйлчилгээ.

21.2.Энэ хуулийн 21.1.1-д заасан тусламж, дэмжлэгийг Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулна.

21.3.Энэ хуулийн 21.1.2-т заасан тусламж, дэмжлэг үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, зардлыг төсвийн багцаасаа гаргана.

#### **22 дугаар зүйл.Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ**

22.1.Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд дараах өрхийн гишүүн-иргэн, иргэнийг хамруулна:

22.1.1.энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн-иргэдийн дотроос нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлсон хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;

22.1.2.гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэн.

22.2.Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нь дараах хэлбэртэй байна:

22.2.1.хүнсний бүтээгдэхүүн, эсхүл хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичиг олгох;

22.2.2.халуун хоол, цайгаар үйлчлэх.



22.3.Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хөтөлбөр, журам, хэмжээг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

22.4.Энэ хуулийн 13.1.2-т заасан тэтгэмж, 20.2.1, 21.1.1, 22.1.1-д заасан үйлчилгээ тус бүрд хамруулах нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнийг тодорхойлох журмыг Засгийн газар батална.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

### **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

#### **23 дугаар зүйл.Нийгмийн халамжийн асуудал эрхлэх байгууллага**

23.1.Нийгмийн халамжийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутагт тухайн шатны Засаг дарга тус тусын эрх хэмжээний хүрээнд эрхэлнэ.

#### **24 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, хяналт**

24.1.Нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтнаас бүрдэнэ.

24.2.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий агентлаг байна.

24.3.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг хуульд заасны дагуу нэр дэвшүүлж нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, аймаг, нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

[/Энэ хэсгийг 2012 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ хэсэг т 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

24.4.Сумын нийгмийн ажилтныг сумын Засаг даргатай зөвшилцөн аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга, хорооны нийгмийн ажилтныг дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

24.5.Сум, хорооны нийгмийн ажилтны орон тооны жишиг нормативыг тухайн засаг захиргааны нэгжийн хүн ам, нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоог харгалзан нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24.6.Тэтгэвэр, тэтгэмж олгох, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан зохион байгуулна.

24.7.Нийгмийн халамжийн хяналтыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсэг т 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

24.8.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нийгмийн халамжийн үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх, тэтгэвэр, тэтгэмжийн олголт, үйлчилгээний чанар хүртээмж болон халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг бүхий хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжтэй байна.

[/Энэ хэсэг т 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

24.9.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 24.8-д заасан чиг үүрэг бүхий ажилтантай байна.

#### **25 дугаар зүйл.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**

25.1.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.1.1.халамжийн сан бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах, тайлагнах;

25.1.2.халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах;

25.1.3.нийгмийн халамжийн байгууллагын үйл ажиллагааны арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлах;

25.1.4.нийгмийн халамжийн болон асрамжийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулах, тэдгээрт мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

25.1.5.доод шатны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

- 25.1.6.олон улсын болон гадаад улсын ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах;
- 25.1.7.энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг өөрчлөх, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээг сайжруулах талаар санал боловсруулж, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад оруулах;
- 25.1.8.шаардлагатай тохиолдолд аймаг, нийслэл, дүүргийн халамжийн сангийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлж нэгдсэн журмаар хуваарилан зарцуулах;
- 25.1.9.нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбогдсон иргэд, байгууллагын санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;
- 25.1.10.аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын албан тушаалтны гаргасан хууль бус шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох;
- 25.1.11.хүн ам, гэр бүл, нийгмийн хөгжлийг дэмжих чиглэлээр батлагдсан үндэсний хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 25.1.12.нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, холбогдох бусад баримт бичгийг байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах.

## **26 дугаар зүйл.Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний зохион байгуулалт**

- 26.1.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг улс, бүс, орон нутгийн асрамжийн газар, тасаг үзүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээг аймаг, нийслэл, дүүргийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан зохион байгуулна.
- 26.2.Иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ үзүүлж болно.
- 26.3.Энэ хуулийн 26.2-т заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэж, гэрчилгээ олгоно.
- 26.4.Энэ хуулийн 26.2-т заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага асруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хохироосон бол тухайн үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргана.
- 26.5.Энэ хуулийн 26.2-т заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үзүүлэх нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний зардлыг орон нутгийн төсөв, халамжийн сангаас гэрээний үндсэн дээр хэсэгчлэн буюу бүрэн санхүүжүүлж болно.
- 26.6.Энэ хуулийн 26.2-т заасан нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх этгээдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталж мөрдүүлнэ.

## **27 дугаар зүйл.Амьжиргааг дэмжих зөвлөл**

27.1.Энэ хуулийн 3.1.2, 3.1.5, 18.2.4-т зааснаас бусад иргэнийг нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах эсэх талаар шийдвэр гаргах, халамжийн үйл ажиллагаатай холбогдсон гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүрэг бүхий Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ сум, хороонд ажиллана.

[/Энэ хэсэгт 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

27.2.Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сум, хорооны Засаг даргын санал болгосноор сум, хороонд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж батална.

27.3.Зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дараах төлөөллөөс бүрдэнэ:

- 27.3.1.нийгмийн ажилтан 1 хүн;
- 27.3.2.төрийн байгууллагын төлөөлөл 2 хүн;
- 27.3.3.иргэний төлөөлөл 2 хүн;
- 27.3.4.төрийн бус байгууллагын төлөөлөл 2 хүн.

27.4.Зөвлөлийн гишүүнд Засаг даргыг нэр дэвшүүлэхгүй.

27.5.Энэ хуулийн 27.3.3, 27.3.4-т заасан Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 2 жил байх бөгөөд уг гишүүнийг нэг удаа улируулан сонгож болно.

27.6.Зөвлөлийн үйл ажиллагаанд суманд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, хороонд иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчид хяналт тавьж ажиллана.

27.7.Зөвлөлийн шийдвэр нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд зааснаас бусад тохиолдолд нийтэд нээлттэй, ил тод байна.

[/Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

27.8.2000-аас дээш хүн амтай баг, тосгонд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр Зөвлөл ажиллуулж болно.

27.9.Зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдон гарах зайлшгүй зардлыг халамжийн сангаас санхүүжүүлнэ.

27.10.Зөвлөлийн гишүүнд болон сум, хорооны нийгмийн ажилтанд ажлын оролцоо, идэвх чарамалтыг харгалзан улиралд нэг удаа урамшуулал олгох бөгөөд уг урамшууллын хэмжээ, олгох журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын

гишүүн батална.

27.11.Энэ хуулийн 27.10-т заасан урамшууллын зардлыг халамжийн сангаас санхүүжүүлнэ.

27.12.Зөвлөлийн дүрмийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## 28 дугаар зүйл.Нийгмийн ажилтан

28.1.Нийгмийн ажилтны мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш түвшний боловсролтой, нийгмийн ажлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, ажил, үйлчилгээ явуулах эрх авсан иргэнийг нийгмийн ажилтнаар ажиллуулна.

28.2.Нийгмийн ажилтан нь мэргэжлийн ёс зүйн дүрэмтэй байна.

28.3.Нийгмийн ажилтан нь мэргэжлийн ёс зүйг чандлан сахиж, ажил, үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээ болон хувийн тэмдэг авсан байна.

28.4.Нийгмийн ажилтанд ажил, үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээ, хувийн тэмдэг олгох, ёс зүйн дүрэм батлан сахиулах ажиллагааг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх орон тооны бус зөвлөл гүйцэтгэнэ.

28.5.Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн нь нийгмийн ажлын мэргэжлийн холбоод, нийгмийн ажилтан бэлтгэдэг их, дээд сургууль, холбогдох төрийн захиргааны байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

28.6.Энэ хуулийн 28.4-т заасан орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах дүрэм, зөвлөлийн гишүүнд олгох урамшууллын хэмжээг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28.7.Орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох зайлшгүй зардал, орон тооны бус зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллыг халамжийн сангаас санхүүжүүлнэ.

28.8.Нийгмийн ажилтан дор дурдсан үүрэг хүлээнэ:

28.8.1.тухайн сум, хорооны нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаа гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх;

28.8.2.нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний нөхцөл байдлыг үнэлж, хөгжлийн төлөвлөгөөг тухайн өрх, иргэнтэй хамтран хийж, хэрэгжүүлэх;

28.8.3.тэтгэвэр, тэтгэмж авах, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг тодорхойлж, шийдвэрлүүлэх;

28.8.4.өрх, иргэдийг хүсэл, зорилго, хэрэгцээгээрээ бүлэг болгон зохион байгуулагдахад нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

28.8.5.өрх, иргэдийг амьжиргаагаа дээшлүүлэх чадавхтай болоход нь туслах зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

28.8.6.орон нутгийн иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах;

28.8.7.нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж;

28.8.8.нийгмийн ажилтанд хандсан хувь хүний /хууль зөрчсөн үйлдлийг мэдээлэхээс бусад тохиолдолд/ нууцыг чандлан хадгалах;

28.8.9.нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж, журам, зааврыг хэрэгжүүлэх;

28.8.10.хүн ам, гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр батлагдсан үндэсний хөтөлбөр, арга хэмжээг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлыг эрүүл мэндийн, боловсролын болон бусад нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулах.

28.8.11.иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний талаар бүрэн мэдээлэл өгөх;

[/Энэ заалтыг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

28.8.12.өрх, иргэнийг нийгмийн халамжийн үйлчилгээнд үр дүнтэй хамруулах зорилгоор эрүүл мэнд, боловсролыг дэмжих зэрэг нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай зуучилж өгөх.

[/Энэ заалтыг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

28.9.Нийгмийн ажилтан дор дурдсан эрх эдэлнэ:

28.9.1.нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх байгууллага, иргэнийг сонгоход оролцох, үйлчилгээнийх нь чанарт хяналт тавих, үнэлгээ хийх;

28.9.2.шаардлагатай мэдээ, судалгаа болон холбогдох баримт бичгийг тухайн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

28.9.3.халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн бусад баримттай холбогдсон тайлбар, лавлагаа гаргуулж авах;

28.9.4.мэргэжлийн ёс зүй, эрх, үүрэгт нь болон үйлчлүүлэгчид харш үйлдэл гүйцэтгэхээс татгалзах;

28.9.5.нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд орон нутгийн байгууллага, иргэнийг татан оролцуулах;

28.9.6.ажлын онцлогоос шалтгаалан тусгай өрөө, эсхүл тусгаарлалт бүхий ажлын байр болон шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангагдах.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГСДЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦОО

#### 29 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн бүртгэл, мэдээлэл

29.1.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагсдын болон энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хэвийн ажиллуулах, тухай бүр шинэчлэх үүрэг хүлээнэ.

29.2.Энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журмыг Засгийн газар батална.

[/Энэ заалтыг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

29.3.Энэ хуулийн 29.1-д заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг халамжийн сангаас санхүүжүүлнэ.

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### БУСАД ЗҮЙЛ

#### 30 дугаар зүйл.Тэтгэвэр, тэтгэмжийг зогсоох, түүнээс суутгал хийх

30.1.Тэтгэвэр, тэтгэмж авагч хуурамч бичиг баримт бүрдүүлж тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авсан нь тогтоогдвол уг тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг зогсооно.

30.2.Тэтгэвэр, тэтгэмж авагч хуурамч бичиг баримт бүрдүүлсний улмаас илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг нөхөн төлүүлэх тухай шүүхийн шийдвэр, эсхүл улсын байцаагчийн шийдвэр гарсан бол суутгал хийж болно.

30.3.Энэ хуулийн 30.2-т заасан суутгалын хэмжээ нь сарын тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээний 50 хувиас хэтэрч болохгүй.

30.4.Энэ хуулийн 30.2-т зааснаас бусад тохиолдолд тэтгэвэр, тэтгэмжээс суутгал хийхийг хориглоно.

30.5.Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, ажилтны гаргасан алдааны улмаас илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг буцаан суутгахгүй бөгөөд хохирлыг шүүхийн журмаар буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.

#### 31 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

31.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

31.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

[/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

#### 32 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

32.1.Энэ хуулийг 2012 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ